



**АВСТРАЛИ УЛСЫН КҮЙНСЛАНД  
МУЖИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ  
(Эрүүгийн хэрэг<sup>1</sup>)**

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГТ “ҮНДЭСЛЭЛ БҮХИЙ ЭРГЭЛЗЭЭНЭЭС АНГИД БАЙХ”  
НОТОЛГООНЫ СТАНДАРТЫГ МӨРДӨНӨ**

***P Э АБРАХАМ***

**[2021] QDC 65**

**САНАМЖ:** Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын давж заалдах шатны шүүхийн шийдвэр болно.

**ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ**

Шүүгдэгч нь тухайн цаг хугацаанд өөрийн асран хамгаалалтад байсан 16 насанд хүрээгүй хүүхдэд гурван удаагийн ёс бус үйлдэл *indecent act*/ хийсэн хэрэгт холбогджээ. Түүнийг хохирогчийн бэлэг эрхтний хоёр хажуу тал болон бэлэг эрхтэнд хүрсэн гэж буруутгажээ. Шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан байна.

**ХУУЛИЙН ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР**

Гэмт хэрэг үйлдэгдэх үеийн хохирогчийн нас нь нэгэнт нотлогдсон баримт учраас энэ хэргийн хувьд хохирогчийн нас гол хамааралтай асуудал биш юм. Түүнчлэн, хэрэв шүүгдэгч хохирогчийн биед гараараа хүрсэн бол тэдгээр үйлдлүүд нь ёс бус төдийгүй хууль бус үйлдэл мөн эсэх талаарх асуудал хөндөгдөөгүй байна.

Харин энэхүү хэргийн хувьд хөндөгдөж буй гол асуудал нь шүүгдэгч хохирогчийн биед хүрсэн гэх үйлдлүүдийг үйлдсэн эс үйлдсэн, мөн шүүгдэгчийн асран хамгаалалтад байсан насанд хүрээгүй хүүхэд бодит явдлыг ярьж байгаа эсэх юм. Хохирогчийн талаас гаргасан нотлох баримтуудыг хуулийн дагуу урьдчилан баримтжуулж шүүх хуралдааны явцад танилцуулсан. Шүүгдэгч цагдаад мэдүүлэг өгч, шүүх хуралдаанд нотлох баримт гаргаж өгсөн бөгөөд тэрээр өөрийг нь

<sup>1</sup> Эх сурвалж: [https://archive.sclqld.org.au/qjudgment/2021/Judgment\\_Summary\\_2021\\_QDC%2065.pdf](https://archive.sclqld.org.au/qjudgment/2021/Judgment_Summary_2021_QDC%2065.pdf)  
Хураангуйг орчуулахдаа эх хувилбарын бүтцийг өөрчилсөн болно.  
Шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: <https://archive.sclqld.org.au/qjudgment/2021/QDC21-065.pdf>



буруутгаж буй үйлдлүүдийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзжээ. Түүнчлэн хохирогч гэртээ ирсний дараа сэтгэл санааны хувьд илэрхий хямарсан байсан тухай хохирогчийн ээжийн мэдүүлэг хавтаст хэрэгт авагджээ. Хохирогчийг худал ярьж байна гэж үзэх илт сэжүүр хэрэгт байгаагүй болно.

Энэ хэрэг нь “мэдүүлгийн эсрэг мэдүүлэг” */word versus word/*-ийн нотлох баримтыг үнэлэх тухай маргаантай асуудлыг хөндсөн. Хохирогч талаас ач холбогдол бүхий нотлох баримтуудыг гаргасан бөгөөд хохирогчийн сэтгэл санааны байдал нь яллах талын байр суурийг улам дэмжиж байв. Шүүгдэгч талаас гэмт хэрэг үйлдэгдсэн гэх тухайн өдөр хохирогчид зүй бус үйлдэл хийгээгүй талаар маргаж шүүх хуралдаанд нотлох баримтуудыг гаргаж өгсөн байна. Дээрхээс үзэхэд энэхүү хэргийн хүрээнд прокурор шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэдгийг “үндэслэл бүхий эргэлзээнээс ангид байх” */beyond reasonable doubt/* нотолгооны стандартыг<sup>2</sup> хангахуйц түвшинд тогтоож чадсан уу гэх асуулт тавигдана.

Яллах талын байр суурь үндэслэл бүхий бөгөөд хохирогчийн зүгээс ач холбогдол бүхий нотлох баримтуудыг гаргаж өгөхийн сацуу сэтгэл санааны хямралд орсон болох нь харагдаж байсан. Хэргийн нөхцөл байдал нь таамаглалт стандартыг */standard of probability/* хангахуйц хэмжээнд нотлогдсон. Гэсэн хэдий ч анхан шатны шүүхээс нотлох баримтуудад үндэслэсэн дүгнэлт нь үндэслэл бүхий эргэлзээнээс ангид байх стандартыг хангаж чадаагүй учраас шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруугүйд тооцжээ.

Орчуулсан: З.Янжинлхам  
Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн  
Эрүүгийн эрх зүйн судлаач

<sup>2</sup> Жишгийн эрх зүйн бүлийн орнуудад эрүүгийн хэрэгт мөрдөгдөх нотолгооны стандарт буюу прокуророос шүүх хуралдаанд танилцуулсан нотлох баримтууд болон дэвшүүлсэн үндэслэлүүд нь шүүгдэгчийн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болохыг эргэлзээгүйгээр тодорхой харуулж байхыг хэлнэ.

Эх сурвалж:

[https://www.law.cornell.edu/wex/beyond\\_a\\_reasonable\\_doubt#:~:text=This%20means%20that%20the%20prosecution,to%20render%20a%20guilty%20verdict.](https://www.law.cornell.edu/wex/beyond_a_reasonable_doubt#:~:text=This%20means%20that%20the%20prosecution,to%20render%20a%20guilty%20verdict.) (Сүүлд үзсэн: 2023.08.15)